

Title	トゥヴァ語におけるモンゴル語との言語接触について ：特に借用語と形状語に言及して
Author(s)	Yamaakhuu, Badamkhand
Citation	大阪大学世界言語研究センター論集. 2011, 5, p. 63-78
Version Type	VoR
URL	https://hdl.handle.net/11094/3915
rights	
Note	

Osaka University Knowledge Archive : OUKA

<https://ir.library.osaka-u.ac.jp/>

Osaka University

ТУВА ХЭЛЭН ДЭХ МОНГОЛ ХЭЛНИЙ “ХЭЛНИЙ КОНТАКТ”: ЯЛАНГУЯА ЗЭЭЛДСЭН ҮГ, ДҮРСЛЭХ ҮГИЙГ АВЧ ҮЗСЭН НЬ

ЯМААХҮҮГИЙН Бадамханд *

要旨

トゥヴァ語におけるモンゴル語との言語接触について —特に借用語と形状語に言及して—

トゥヴァ語は、チュルク系言語に属するが、モンゴル語と地域的に隣接し、長期間に渡る言語接触の結果、モンゴル語からかなり多くの借用語を取り入れている。

本稿は、一つは、トゥヴァ語におけるモンゴル語借用語に関し、とりわけ音声・形態・意味・語彙等の点から、その主な特徴を明らかにすること、もう一つは、トゥヴァ語の形状語(形状動詞・形状名詞)に関し、モンゴル語との言語接触の点から、その形態的特徴にまつわる内部構造を明らかにすることの二つを主な目的とするものである。

考察の結果、前者の問題に関しては、まず音声的には、1. 語頭有声音 $з\sim ж, г$ の無声化、2. 語頭破擦音 $ц\sim ч$ の摩擦音化、3. 語中無音声 $т, х, с\sim ц, ш\sim ч$ の有声化、4. 唇音調和の不成立、5. “iの折れ”の不成立、6. 語末短母音の保持、7. $б\sim м$ の子音交替、8. 音位転換、9. 音脱落等の現象が見られること、また形態的には、1. “隠れた-n”の保持、2. 派生接尾辞の相違、3. 派生接尾辞の生産性の差異、4. モンゴル語起源語幹+トゥヴァ語異源接尾辞語形等が見られること、さらに意味的には、1. 意味の狭義化、2. 意味の広義化、3. 意味の不一致、4. 意味の逆転、5. 方言差による意味のずれ等の現象が見られること、最後に語彙的には、1. 全品詞による語彙借用、2. 西モンゴル・オイラト方言特殊語彙、3. オイラト異同・モンゴル語共通語彙等が見られることを、それぞれ明らかにした。

さらに、後者の問題に関しては、トゥヴァ語の形状語を、形状動詞と形状名詞に分け、分析の結果、形状動詞は、a) モンゴル語借用形状動詞 -Vй 形と b) トゥヴァ語固有形状動詞 -Vй 形 / -Vp 形から成ること、また形状名詞は、a) モンゴル語起源接尾辞形式 1. -гар, 2. -гай, 3. -р, 4. -н, -н, -к 等の4種、及び b) トゥヴァ語固有接尾辞形式 -ш 形から成ることをそれぞれ明らかにし、一般にモンゴル語の形状語がトゥヴァ語の形状語成立・発展に形態的に深くかかわっていることを言語接触の点から説明した。

* 大阪大学 外国語学部 非常勤講師

Keywords : Mongolian, Tuvian, language contact, loanwords, figurative words

キーワード : モンゴル語, トゥヴァ語, 言語接触, 借用語, 形状語

0. Эхлэл

Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тува Улсад хэрэглэдэг тува хэл нь түрэг төрлийн хэлнүүдэд хамаарагддаг бөгөөд тува хэлээр яригч хүн амын тоо нь 250 мянга шахам юм.

Тува хэл нь монгол хэлтэй зэргэлдээ оршдог бөгөөд урт удаан хугацааны турш монгол хэлтэй харьцаатай байсны үр дүнд тува хэлний үгсийн сангийн нэлээд хувийг монгол хэлний гаралтай үг эзэлдэг болсон байна.

Юуны өмнө тува хэлэн дэх монгол хэлний “хэлний контакт” нь “зээлдсэн үг”-энд шууд, “дүрслэх үг”-энд шууд бус тусгагдаж байгааг дурдууштай байна.

Урьдын судалгааны тухайд гэвэл В. И. Рассадин 1980 онд хэвлүүлсэн *Монголо-Бурятские заимствования в Сибирских Тюркских языках* гэдэг номынхоо “Монголизмы в Тувинском языке” х.58-65 хэсэгт монгол хэлнээс тува хэлэнд орсон “зээлдсэн үг”-ийн тухайд голдуу авиан зүйн талаар товчхон дурдсанаас биш, бусад үг зүй, утга зүйн талаар маш бага дурдсанаар барахгүй, ялангуяа “дүрслэх үг”-ийн талаар бол огт дурдаагүй байна.

Иймд тус өгүүлэлдээ эхлээд монгол хэлнээс тува хэлэнд орсон “зээлдсэн үг”-ийн гол онцлогийг, тухайлбал 1. авиан зүй, 2. үг зүй, 3. утга зүй, 4. үгсийн сан зэргийн үүднээс тодорхойлохыг зорилоо. Дараа нь тува хэлэн дэх “дүрслэх үг” (дүрслэх үйл үг, дүрслэх нэр үг хоёрыг багтаана)-ийг тусгайлан авч, дотор нь 1. монгол хэлний гаралтай дүрслэх үг, 2. тува хэлний өвөрмөц дүрслэх үг гэж хоёр хувааж, ер нь тус хэлэн дэх дүрслэх үгийн хэлбэрийн онцлогийг монгол хэлний “хэлний контакт”-ын үүднээс аль болох тодорхойлохыг зорилоо.

1. Монгол хэлнээс тува хэлэнд орсон “зээлдсэн үг”-ийн гол онцлог

Монгол хэлнээс тува хэлэнд орсон зээлдсэн үгийн гол онцлогийг 1.1 авиан зүй, 1.2 үг зүй, 1.3 утга зүй, 1.4 үгсийн сан зэргийн үүднээс авч үзвэл дараах байдалтай байна.

1.1 Авиан зүйн онцлог

1.1.1 Монгол хэлний үгийн эхний дуугай гийгүүлэгч $з \sim ж (< \check{ж})$, $г (< \gamma, g)$ авиа нь тува хэлэнд голдуу дуугүй гийгүүлэгч $ч$, $к \sim х$ авиатай тохиролцоно.

<u>Тува</u>	<u>Монгол</u>
чалыы	залуу
	《молодой, юный》

<u>черге</u>	зэрэг	《разряд》
<u>чыргал</u>	жаргал	《блаженство》
<u>чимис</u>	жимс	《фрукт》
<u>камна-</u>	гамна-	《экономить》
<u>хомуда-</u>	гомдо-	《жаловаться》
<u>керээ</u>	гэрээ	《договор》
<u>херел</u>	гэрэл	《луч》

1.1.2 Монгол хэлний үгийн эхний хамжин шүргэх гийгүүлэгч ц ~ ч (< ǰ) авиа нь тува хэлэнд голдуу шүргэх гийгүүлэгч ш авиатай тохиролцоно.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
<u>шак</u>	цаг	《час, время》
<u>шооча</u>	цоож	《замок》
<u>шөлээн</u>	чөлөө	《свободно》
<u>шимээн</u>	чимээ	《шум, звон》

1.1.3 Монгол хэлний үгийн дунд орсон дуугүй гийгүүлэгч т, х (< q, k), с ~ ц, ш ~ ч авиа нь тува хэлэнд голдуу дуугай гийгүүлэгч д, г, з, ж авиатай тохиролцоно.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
<u>идеге-</u>	итгэ-	《полагаться》
<u>чугула</u>	чухал	《важный》
<u>делегей</u>	дэлхий	《мир》
<u>күзел</u>	хүсэл	《желание》
<u>онзагай</u>	онцгой	《особенный》
<u>кажаа</u>	хашаа	《двор, хлев》
<u>бижи-</u>	бичи-	《писать》

1.1.4 Монгол хэлэнд үгийн нэгдүгээр үед уруулын эгшиг о, ө орвол түүнээс хойшхи үед уруулаар зохицдог (“labial harmony”) байхад тува хэлэнд уруулаар зохицохгүй байна. Энэ нь баруун монголын ойрд аялгууны онцлогтой адил үзэгдэл юм.

<u>Тува</u>	<u>Ойрд</u>	<u>Монгол</u>	
<u>чогаал</u>	[zɔka:l]	зохиол	《произведение》
<u>тодаргай</u>	[tɔdaxa:]	тодорхой	《ясный》
<u>өршээл</u>	[øtʃæ:l]	өршөөл	《прощение》
<u>көдээ</u>	[kɔdæ:]	хөдөө	《деревня》

1.1.5 Монгол хэлэн дэх *и-гийн нугарал* (“i-breaking”) болсон жишээ үгнүүдээс үзэхэд тува хэлэнд ихэнх нь и-гийн нугарал болоогүй нь олонтоо харагдаж байна.

<u>Тува</u>	<u>Монгол бичгийн хэл</u>	<u>Монгол</u>	
хирээ	kirüge	хөрөө	《пила》
чылдагаан	siltayan	шалтгаан	《причина》
чыраа	ǰiruʻa	жороо	《иноходь》
шынар	ǰinar	чанар	《качество》
шырай	ǰirai	царай	《лицо》
ылга-	ilya-	ялга-	《отличать》

1.1.6 Монгол бичгийн хэлний үгийн төгсгөлийн богино эгшиг нь монгол хэлэнд гээгдсэн байхад энэ нь тува хэлэнд харьцангуй тод хадгалагдаж байна. Энэ үзэгдэл нь тува хэлний үгийн өргөлт сүүлчийн үед байдагтай холбоотой юм.

<u>Тува</u>	<u>Монгол бичгийн хэл</u>	<u>Монгол</u>	
аптара	abdara	авдар	《сундук》
сүге	süke	сүх	《топор》
ёзү	yosu	ёс	《обычай》
хүндү	kündü	хүнд	《уважение》
хээли	kegelǰ	хээл	《взятка》

1.1.7 Монгол хэлнээс тува хэлэнд орохдоо уруулын гийгүүлэгч б ~ м сэлгэсэн тохиолдол нэлээд харагдаж байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
маадыр	баатар	《герой》
мойтук	бойтог	《мягкая детская обувь》
дээрбе	тээрэм	《мельница》
дээрбечи	дээрэмчин	《грабитель》
шырбай-	чармай-	《стараться》

1.1.8 Монгол хэлнээс тува хэлэнд орохдоо авиа тонгорсон үзэгдэл (“metathesis”) ч бас байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
башкы	багш	《преподаватель》
утку-	угта-	《встречать》
хуна	ухна	《козёл-производитель》
хүлер	хүрэл	《бронза》
чыскаал	жагсаал	《строй》
шигбей	шөвөг	《шило》

1.1.9 Монгол хэлнээс тува хэлэнд орохдоо авиа гээгдсэн үзэгдэл (“elision”) ч мэр сэр харагдаж байна.

а) Үгийн эхэнд орсон авиа гээгдсэн нь (“aphaeresis”):

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
элээн	нэлээн	《довольно》

б) Үгийн дунд орсон авиа гээгдсэн нь (“syncope”):

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
очулга	орчуулга	《перевод》
хевир	хэлбэр	《форма》

в) Үгийн адагт орсон авиа гээгдсэн нь (“arose”):

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
бала	балаг	《вина》

1.2 Үг зүйн онцлог

1.2.1 Монгол хэлнээс тува хэлэнд орсон зарим нэр үгийн жишээнээс үзэхэд *тогтворгүй -н* (“unstable -n”) хэлбэрийг нэрлэхийн тийн ялгалд хадгалж байгаа нь нэлээд олон жишээнээс харагдаж байна. Энэ нь бас баруун монголын ойрд аялгууны онцлогтой адил үзэгдэл юм.

<u>Тува</u>	<u>Ойрд</u>	<u>Монгол</u>	
адыгуузун	[adʊːsn]	адгуус	《животное, скотина》
доозун	[tɔːsn]	тоос	《пыль》
өжээн	[øʃæːn]	өшөө	《мечь》
хураган	[xʊrgʊn]	хурга	《ягнёнок (до года)》
шимээн	[ʃimæːn]	чимээ	《шум, звон》

1.2.2 Монгол гаралтай үгийн үндсэнд үг бүтээх дагавар залгахдаа тува, монгол хоёр хэлэнд тус тус өөр өөр дагавар залгаж үг бүтээж байгаа сонирхолтой жишээ нэлээд байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
ажылда-	ажилла-	《работать》
(< ажыл)	(< ажил)	(< 《работа》)
кичээлде-	хичээлдэ-	《заниматься》
(< кичээл)	(< хичээл)	(< 《урок, занятие》)
сонгулда	сонгууль	《избрание》
(< сонгу-)	(< сонго-)	(< 《избирать》)
торгаал	торгууль	《штраф》
(< торгаа-)	(< торго-)	(< 《штрафовать》)

1.2.3 Монгол гаралтай үгийн үндсэнд залгах дагаврын хүрээ нь тува, монгол хоёр хэлэнд эрс ялгаатай болох нь ч харагдаж байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
чолаачы	жолооч	《шофёр》
> чолаачыла-	>*жолоочло-	《водить автомашину》
	(→ машин жолоодо-)	
агаар	агаар	《воздух》
> агаарла-	>*агаарла-	《прогуливаться》
	(→ салхила-)	
делге-	дэлгэ-	《выставлять》
> делгелге	>*дэлгэлэг	《выставка》
	(→ үзэсгэлэн)	

1.2.4 Монгол хэлнээс тува хэлэнд орохдоо монгол гаралтай үгийн үндсэнд тува хэлний өвөрмөц дагавар залгаж бүтсэн сонирхолтой жишээ ч мэр сэр байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
өрээл	өрөө	《комната》
(< өрээ + л)		
сакпыт	савх	《палочки для еды》
(< сакпы + т <*saqba (metathesis) < sabqa)		
колдуунда	《в основном》 голдуу	《преимущественно》
(< колдуу + н + да)		

1.3 Утга зүйн онцлог

1.3.1 Монгол хэлнээс тува хэлэнд орохдоо утга нь явцуурсан үг ч хааяа нэг тохиолдож байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>
дегээ	дэгээ
《подсечка (приём национальной борьбы)》	《1. крюк 2. подножки (приём борьбы)》
додар	дотор
《подкладка》	《1. внутренний 2. внутри 3. среди 4. в течение 5. подкладка》
доктаа-	тогто-
《останавливаться》	《1. утверждаться 2. решать 3. останавливаться》

1.3.2 Монгол хэлнээс тува хэлэнд орохдоо утга нь харин ч өргөжсөн үг ч бас тохиолдож байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>
бажың	байшин
《1. здание 2. <u>тюрьма</u> 》	《здание》
бадыла-	батла-
《1. <u>голосовать</u>	《утверждать》
2. утверждать	
3. <u>регистрировать</u> 》	

1.3.3 Монгол хэлнээс тува хэлэнд орохдоо утга нь тэс ондоо болсон үг ч бас мэр сэр байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>
авьяас 《лукавство》	авьяас 《талант》
бөдүүн 《простой》	бүдүүн 《1. толстый 2. грубый》
чугаа 《1. язык 2. разговор》	зугаа 《развлечение》
(> чугаала- 《говорить》)	(> зугаала- 《гулять》)
шөл 《1. поле 2. площадь》	цөл 《пустыня》

1.3.4 Монгол хэлнээс тува хэлэнд орохдоо хос үгийн утга нь яг эсрэг болох ховор үзэгдэл ч харагдаж байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>
содак шуудак	зодог шуудаг
→ содак 《трусики	→ зодог 《рубашка》
(в национальной борьбе)》	
шуудак 《рубашка	шуудаг 《трусики》
(в национальной борьбе)》	

1.3.5 Тува хэлэнд үгийн утга нь баруун монголын ойрд аялгуугаар биш, монгол хэл тэр чигээрээ орсон үг ч мэр сэр байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	<u>Ойрд</u>	<u>Өвөр монгол</u>
чары-	зара-	[zar-]	[ɟʒar-]
《1. <u>продавать</u>	《1. расходовать	《1. использовать	《1. 用, 使用(использовать)
2. израсходовать》	2. <u>продавать</u> 》	2. посылать》	2. 消費(расходовать)
			3. 派遣(посылать)》

Дээр дурдсан монгол хэлний тус үгийн «продавать (худалдах)» гэсэн утга нь ойрд, өвөр монголын аялгуунд байхгүйгээс үзэхэд монгол хэлнээс тува хэлэнд шууд нөлөөлсөн нь лавтай байна.

1.4 Үгсийн сангийн онцлог

1.4.1 Монгол хэлнээс тува хэлэнд орсон үгнүүдийг үгсийн аймгийн дагуу хувааж, тохирох жишээг таган доор харуулья.

а) Нэр үг

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
ажыл	ажил	«работа, труд»
назы	нас	«возраст»
хааржак	хайрцаг	«ящик»
чурук	зураг	«картина, фотокарточка»

б) Үйл үг

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
адаарга-	атаарха-	«завидовать»
кайга-	гайха-	«удивляться»
чова-	зово-	«беспокоиться»
шиме-	чимэ-	«украшать»

в) Сул үг

<u>Тува</u>	<u>Монгол</u>	
база	бас	«и, ещё»
дагын	дахин	«снова, опять»
харын	харин	«а, но»
ылаңгыя	ялангуяа	«особенно»

1.4.2 Тува хэлэнд баруун монголын ойрд аялгуунаас орсон өвөрмөц үг мэр сэр харагдаж байна.

<u>Тува</u>	<u>Ойрд</u>	<u>Монгол</u>	
хараача	[хага:tʃ] ¹	тооно	«дымовой круг юрты»
коду	[хэт] ²	ходоод	«желудок»

1 Ойрд аялгууны [хага:tʃ] гэдэг нь [хаг-] «смотреть» гэсэн үйл үгийн үндсэн дээр [-а:tʃ] (Мо. -үай) гэсэн үйлээс нэр үг бүтээх дагавар залгасан хэлбэр болно.

2 Ойрд аялгууны [хэт] гэдэг нь монгол хэлний ходоод (Мо. qoduyudu <*qotu-γādu) гэдэгтэй хэлбэр болон утгаараа гарал нэгтэй бөгөөд буриад хэлэнд ч хото «желудок»

1.4.3 Мөн дээр дурдсанаас эсрэгээр тува хэлэнд баруун монголын ойрд аялгуугаар биш, харин ч монгол хэл тэр чигээрээ орсон үг ч бас байна.

<u>Тува</u>	<u>Монгол</u>	<u>Ойрд</u>	<u>Өвөр монгол</u>
хөөрге	хөөрөг	[køky:r] ~ [køkø:r]	[xøxu:r] «табакерка»

2. Тува хэлний “дүрслэх үг”-ийн хэлбэрийн онцлогийг монгол хэлний “хэлний контакт”-ын үүднээс тодорхойлох нь

2.1 Монгол хэлний дүрслэх үг

Монгол хэлний дүрслэх үг гэдэг нь хүн болон юмны хэлбэр дүрс байдал заах утгатай, (C)V(C) · CVй-³(C – гийгүүлэгч, V – эгшиг, Vй – хос эгшиг, зарим үед урт эгшигийг заана) гэсэн бүтэцтэй, тухайлбал бамбай- «быть пухлым», гонзой- «становиться продолговатым», цүндий- «быть пузатым» гэх мэт дүрслэх үйл үг болон дүрслэх үйл үгнээс үүссэн (C)V(C) · C(V)гVр бүтэцтэй, тухайлбал бамбай- > бамбагар «пухлый», гонзой- > гонзгор «продолговатый», цүндий- > цүндгэр «пузатый» гэх мэт дүрслэх нэр үг хоёрыг хамтатган хэлж байгаа бөгөөд энэ нь монгол хэлний үгсийн сангийн дотор ихээхэн чухал байр суурь эзэлж байна.

2.2 Тува хэлний дүрслэх үг

2.2.1 Дүрслэх үйл үг

Тува хэлний дүрслэх үйл үгийг хэлбэрийн хувьд үйл үгийн үндэс нь -Vй хэлбэртэй (хос эгшиг, заримдаа урт эгшигийг заана), эсвэл -Vр хэлбэртэй (сүүлчийн -р элемент нь үндэс үүсгэгч (“stem-formative”) юм) гэж хоёр хувааж болох бөгөөд тооны хувьд -Vй хэлбэртэй нь харьцангуй олон, -Vр хэлбэртэй нь харьцангуй цөөн гэсэн онцлогтойг дурдах байна.

гэж тохиолдож байна. Бас манж бичгийн хэлний *kodo* «желудок (малый у жвачных животных)» гэдэг ч монгол хэлний тус хэлбэрээс орсон ч байж болзошгүй байна.

3 Монгол хэлний дүрслэх үйл үгийг (C)V(C) · CVй- гэсэн хэлбэрээр загварчилсан нь дараах дөрвөн хэлбэрийг төлөөлсөн болно.

- а) CVC · CVй- хэлбэр (бар·зай- «быть шершавым»)
- б) CV · CVй- хэлбэр (ба·рай- «стать хмурым»)
- в) VC · CVй- хэлбэр (ар·зай- «быть неровным»)
- г) V · CVй- хэлбэр (а·тий- «сгибать»)

Мөн гарлын хувьд а) монгол хэлний гаралтай дүрслэх үйл үг, б) тува хэлний өвөрмөц дүрслэх үйл үг гэж хоёр хувааж болох юм.

а) Монгол хэлний гаралтай дүрслэх үйл үг

Энэ нь монгол хэлнээс тува хэлэнд шууд орсон дүрслэх үйл үг мөн бөгөөд үүнд таарах монгол бичгийн хэл (Мо.) болон монгол хэлний хэлбэрийг олоход хэцүүгүй юм. Монгол хэлний гаралтай дүрслэх үйл үгийг ерөнхийд нь хэлбэрийн хувьд -Vй хэлбэртэй гэж хураангуйлж болно. Жишээлбэл:

- арзай- 《1. торчать (о скале) 2. скалиться》
(> арзгар) (← Мо. аржай- (> аржайар))
- далбай- 《расправляется (о крыльях)》
(> далбагар) (← Мо. dalbayi- (> dalbayar))
- сарбай- 《растопыриваться》
(> сарбагар) (← Мо. sarbayi- (> sarbayar))
- сеглей- 《1. быть развесистым 2. взлохматиться (о волосах)》
(> сеглегер) (← Мо. segleyi- (> segleger))

б) Тува хэлний өвөрмөц дүрслэх үйл үг

Энэ ангилалд таарах монгол бичгийн хэл болон монгол хэлний хэлбэр үгүйн тул тува хэлний өвөрмөц дүрслэх үйл үг гэж нэрлэе. Бас үүнийг хэлбэрийн хувьд -Vй хэлбэртэй, -Vр хэлбэртэй гэж хоёр хувааж болох бөгөөд тооны хувьд -Vй хэлбэртэй нь илүү олон байгааг онцолмоор байна.

б)-1: -Vй хэлбэртэй

- дыйлай- 《извиваться》 (> дыйлагар) (Мо. —)
- ойтай- 《откидываться》 (> ойтгар) (Мо. —)
- көлдей- 《делаться мешковатым (о шубе)》 (> көлдегер) (Мо. —)
- хертей- 《прогибаться》 (> хертегер) (Мо. —)

б)-2: -Vр хэлбэртэй

- соолбурар- 《вваливаться (о глазах, щеках)》
(> соолбургай ~ соолбураш) (Мо. —)
- үвүрер- 《растрепаться》 (> үвүргей ~ үвүр) (Мо. —)
- дыдырар- 《становиться кудрявым》 (> дыдыраш) (Мо. —)
- шаарар- 《1. просвечивать 2. редеть》 (> шаараш) (Мо. —)

Цуваа цагийн үүднээс үзэхэд эдгээр дүрслэх үйл үг, ялангуяа б)-1: -Vй хэлбэртэй бүлэг үгс нь нэг бол эртний тува хэл буюу өмнө шатны тува хэлнээс

шууд залгамжилж ирсэн, нэг бол эртний тува хэлнээс тува хэл болох явцдаа зэргэлдээх монгол хэлний нөлөөгөөр сүүлд аажмаар шинэ хэлбэр болон үүссэн гэдгийн аль нь зөв болохыг дүгнэхэд тун хэцүү юм.

2.2.2 Дүрслэх нэр үг

Тува хэлний дүрслэх нэр үгийг дотор нь а) монгол хэлний гаралтай дагаварт хэлбэр, б) тува хэлний өвөрмөц дагаварт хэлбэр гэж хоёр хувааж болох юм.

а) Монгол хэлний гаралтай дагаварт хэлбэр

Тува хэлэнд монгол хэлний дүрслэх нэр үг бүтээх дагаврын үг бүтээх ёсны нөлөөгөөр монгол хэлнийхтэй адил 1. -гар, 2. -гай, 3. -р, 4. -н, -н, -к гэх мэт дөрвөн төрлийн дүрслэх нэр үг бүтээх дагавар тохиолдож байна.

1. Мо. -үг хэлбэртэй таарах нь

Монгол хэлнээс шууд орсон дүрслэх нэр үгийн жишээг доор үзүүлье.
аңгар «зияющий» (< аңгай- «зиять») (← Мо. аңгүаг (< аңгүауи-))
кылагар «1. блестящий 2. ясный»

(< кылай- «1. проясниться (о погоде) 2. стать блестящим»)

(← Мо. гилагар (< гилауи-))

саглагар «ветвистый» (< саглай- «становиться ветвистым»)

(← Мо. саглагар (< саглауи-))

күдүгүр «сутулый» (< күдүй- «сутулиться»)⁴

(← Мо. гүдүгер «выпуклый» (< гүдүй- «делаться выпуклым»)

Бас доорх үгс нь монгол бичгийн хэл болон монгол хэлэнд таарах хэлбэр үггүйн тул *тува хэлний өвөрмөц дүрслэх нэр үг* гэж нэрлэе.

дазагар «раскоряченный (о ногах)» (< дазай- «раскорячиться») (Мо. —)

шопугур «вытянутый (о губах)» (< шопуй- «вытягиваться (о губах)») (Мо. —)

метпегр «толстый» (< метпей- «толстеть») (Мо. —)

течигир «с выпуклым затылком»

(< течий- «быть с выпуклым затылком») (Мо. —)

4 Монгол хэлний гаралтай дүрслэх үгнээс тува хэлэнд орохдоо ихэнхдээ уг утгаараа ордог боловч хааяа нэг дээрх шиг утга нь зөрөх тохиолдол ч бас байна.

2. Мо. -yai хэлбэртэй таарах нь

Дараах жишээ үгнүүдийг тува хэлний өвөрмөц дүрслэх үйл үгэнд монгол хэлний дүрслэх нэр үг бүтээх -yai хэлбэрийг залгасан гэж үзэж болмоор байна.

соолбургай «ввалившийся (о глазах, щеках)»

(< соолбурар- «вваливаться (о глазах, щеках)») (Мо. —)

үвүргей «растрёпанный»

(< үвүрер- «растрепаться») (Мо. —)

бүлүргей «1. тусклый 2. матовый»

(< бүлүрер- «быть тусклым») (Мо. —)

имиргей «пришуренный»

(< имирер- «щуриться (о глазах)») (Мо. —)

Дүрслэх нэр үг бүтээхдээ тува хэлний өвөрмөц дүрслэх үйл үгийн үндэс -Vp хэлбэр дэх сүүлчийн элемент -p (үндэс үүсгэгч)-ийг хасч -yai хэлбэрийг залгасан бололтой.

3. Мо. -g хэлбэртэй таарах нь

Дараах жишээнүүдийн дүрслэх үйл үгийн үндэс нь тува хэлний өвөрмөц хэлбэр мөн бөгөөд дүрслэх нэр үг нь -g хэлбэртэй тохиолдож байна.

селбер (~ селбегер) «мохнатый» (< селбей- «растрепаться») (Мо. —)

үвүр (~ үвүргей) «растрёпанный» (< үвүрер- «растрепаться») (Мо. —)

шымыр (~ шымыраш) «низкий»

(< шымырар- «становиться короткими (об ушах)») (Мо. —)

чөлдүр «1. исхудалый 2. хилый»

(< чөлдүрер- «1. худеть 2. становится хилым») (Мо. —)

Эхний жишээ селбер нь дүрслэх үйл үгийн үндэс селбей-гийн сүүлчийн й-г хасчихаад, дүрслэх нэр үг бүтээх -p дагаврыг шууд залгасан бололтой. Бас бусад гурван жишээ нь дүрслэх үйл үгийн -Vp хэлбэрийн сүүлчийн элемент -p (үндэс үүсгэгч)-ийг хасчихаад бүтсэн бололтой.

4. Мо. -n, -ng, -γ /-g хэлбэртэй таарах нь

Мо. -n хэлбэртэй дүйх жишээг доор үзүүлье.

калчаң «лысый» (< калчай- «лысеть») (← Мо. qalǰaң (< qalǰayi-))

ыспаң (~ ыспагар) «похудевший» (< ыспай- «худеть») (Мо. —)

Мо. -ng хэлбэртэй дүйх жишээг доор үзүүлье.

шалдаң «голый» (< шалдай- «обнажаться») (← Мо. šaldang (< šaldayi-))

Дүрслэх үйл үгийн үндэс нь батлагдаагүй боловч Мо. -ng хэлбэртэй дүйх дүрслэх нэр үг ч бас байгааг доорх жишээгээр үзүүлье.

шодаң (~ шодугур) «бесхвостый (о лошади)» (← Мо. *šodung* (< *šoduyi*-))

борзаң (~ борзагар) «зубчатый» (← Мо. *burǰang* (< *burǰayi*-))

коңзаң (~ коңзагар) «с горбинкой, горбатый» (Мо. —)

Мо. -γ/-g хэлбэртэй дүйх жишээг доор үзүүлье.

оңгак «1. вогнутый 2. зияющий» (< оңгай- «зиять») (← Мо. *ongγuyi*-)

майтак «косолапый» (< майтай- «статья косолапым») (← Мо. *mayitii*-)

достак (~ достагар) «выпученный (о глазах)»

(< достаи- «выпучиться (о глазах)») (Мо. —)

дойтук (~ дойтугур) «хромой» (< дойтуи- «хромать») (Мо. —)

чиртек (~ чиртегер) «деформированный (о глазном веке)»

(< чиртей- «деформироваться (о глазном веке)») (Мо. —)

чолдак «1. короткий 2. низкий»

(< чолдай- «1. становится коротким 2. быть низким») (Мо. —)

б) Тува хэлний өвөрмөц дагаварт хэлбэр

Тува хэлний өвөрмөц дүрслэх нэр үг бүтээх дагавар нь -ш хэлбэр юм.

Жишээ нь:

авыраш «растрёпанный» (< авырар- «растрепаться») (Мо. —)

дыдыраш «кудрявый»

(< дыдырар- «становиться кудрявым») (Мо. —)

шаараш «редкий, неплотный»

(< шаарар- ~ шаарай- «1. просвечивать 2. редеть») (Мо. —)

соолбураш (~ соолбургай) «ввалившийся (о глазах, щеках)»

(< соолбурар- «вваливаться (о глазах, щеках)») (Мо. —)

хертеш (~ хертегер) «прогнутый»

(< хертей- «прогибаться») (Мо. —)

Дүрслэх нэр үг бүтээх -ш дагавар нь монгол бичгийн хэл болон монгол хэлэнд үгүйн тул тува хэлний өвөрмөц дагавар мөн бөгөөд дүрслэх нэр үг бүтээхдээ тува хэлний дүрслэх үйл үгийн үндэс -Vp хэлбэрийн сүүлчийн элемент -p (үндэс үүсгэгч)-ийг хасчихаад залгасан, мөн -Vй хэлбэрийн сүүлчийн й-г хасчихаад залгасан бололтой.

Дээрх байдлаас тува хэлний дүрслэх үгийн хэлбэрийн онцлогийг монгол хэлний “хэлний контакт”-ын үүднээс дүгнэн дараах байдлаар хураангуйлж болох юм.

Тува хэлний дүрслэх үгийн хэлбэрийн онцлог

Дүрслэх үйл үг	Монгол хэлний гаралтай үйл үг				Тува хэлний өвөрмөц үйл үг	
	-Vй хэлбэр				-Vй хэлбэр	-Vр хэлбэр
	+				+	+
Дүрслэх нэр үг	Монгол хэлний гаралтай дагавар				Тува хэлний өвөрмөц дагавар	
	1. -гар		2. -гай		-ш	
	Мо.	Тув.	Мо.	Тув.	Мо.	Тув.
	+	+	-	+	-	+
	3. -р		4. -н, -ң, -к			
	Мо.	Тув.	Мо.	Тув.		
-	+	+	+			

(Мо., Тув. “” залгагдах дүрслэх үйл үгийн үндэс нь монгол, тува хэлнийх гэсэн үг)

Товчхон дүгнэж хэлэхэд тува хэлний дүрслэх үйл үгийн тухайд бол **-Vй** хэлбэртэй (угтаа монгол хэлний гаралтай байсан байх) нь монгол хэлний гаралтай үйл үгнээс гадна тува хэлний өвөрмөц үйл үгэнд ч нэлээд тохиолдож байгаа бөгөөд мөн дүрслэх нэр үгийн тухайд бол **-гай, -р** хэлбэртэй (угтаа монгол хэлний гаралтай байсан нь лавтай) нь монгол хэлний гаралтай үйл үгэнд биш, тува хэлний өвөрмөц үйл үгэнд л тохиолдож байна. Иймд дээрх хоёр баримтыг үндэслэвэл ер нь монгол хэлний дүрслэх үг нь хэлбэрийн хувьд тува хэлний дүрслэх үгийн гарал үүсэл, хөгжилд нэлээд гүнзгий нөлөө үзүүлсээр ирсэн гэж дүгнэж болох юм.

3. Төгсгөл

Тува хэлэн дэх монгол хэлний “хэлний контакт”-ын талаар, ялангуяа зээлдсэн үг болон дүрслэх үгийг тусгайлан авч шинжилж үзлээ.

Тус судалгааны үр дүнд дараах хоёр зүйлийг тодруулсан болно.

1. Монгол хэлнээс тува хэлэнд орсон “зээлдсэн үг”-ийн гол онцлогийг хэд хэдэн талаас авч үзлээ. Эхлээд *авиан зүйн талаар*: 1. үгийн эхний дуутай гийгүүлэгч **з ~ ж, г** нь дуугүйших, 2. үгийн эхний хамжин шүргэх гийгүүлэгч **ц ~ ч** нь шүргэх авиа болох, 3. үгийн дунд орсон дуугүй гийгүүлэгч **т, х, с ~ ц, ш ~ ч** нь дуутай болох, 4. эгшиг нь уруулаар зохицоогүй, 5. “и-гийн нугарал” болоогүй, 6. үгийн төгсгөлийн богино эгшиг нь хадгалагдаж байгаа, 7. уруулын гийгүүлэгч **б ~ м** сэлгэх, 8. авиа тонгорох, 9. авиа гээгдэх гэх мэтийн үзэгдэл байгааг, *үг зүйн талаар*: 1. “тогтворгүй -н” хадгалагдаж байгаа, 2. ижил үндсэнд хоёр өөр дагавар залгах тухай, 3. үг бүтээх дагаварын давтамжийн ялгааны тухай, 4. монгол хэлний гаралтай үгийн үндсэнд тува хэлний өвөрмөц дагавар залгах

тухай зэрэг үзэгдэл байгааг, *утга зүйн талаар*: 1. Үгийн утга нь явцуурах, 2. утга нь өргөжих, 3. утга нь тэс ондоо болох, 4. утга нь яг эсрэг болох, 5. нутгийн аялгуунд утга нь зөрөх гэх мэт үзэгдэл байгааг, эцэст нь *үгсийн сангийн талаар*: 1. бүх үгсийн аймаг дахь зээлдсэн үгийн тухай, 2. ойрд аялгуунаас орсон өвөрмөц үг, 3. ойрд аялгуугаар биш, монгол хэл тэр чигээрээ орсон үг гэх мэтээр тус тус тодорхойлон дурдсан билээ.

2. Тува хэлний “дүрслэх үг”-ийн хэлбэрийн онцлогийг монгол хэлний “хэлний контакт”-ын үүднээс тодруулахын тулд эхлээд тува хэлний дүрслэх үгийг дүрслэх үйл үг, дүрслэх нэр үг гэж хоёр хуваан шинжилж үзлээ. Үүний дүнд дүрслэх үйл үг нь а) *монгол хэлний гаралтай дүрслэх үйл үг*: -Вй хэлбэртэй, б) *тува хэлний өвөрмөц дүрслэх үйл үг*: -Вй хэлбэртэй / -Ур хэлбэртэй гэдгээс бүтсэн болохыг, мөн дүрслэх нэр үг нь а) *монгол хэлний гаралтай дагаварт хэлбэр*: 1. -гар, 2. -гай, 3. -р, 4. -н, -н, -к гэх мэт дөрвөн хэлбэртэй, б) *тува хэлний өвөрмөц дагаварт хэлбэр*: -ш хэлбэртэй гэдгээс бүтсэн болохыг тус тус тодруулж, ер нь монгол хэлний дүрслэх үг нь хэлбэрийн хувьд тува хэлний дүрслэх үгийн гарал үүсэл, хөгжилд нэлээн гүнзгий холбоотой болохыг “хэлний контакт”-ын үүднээс тайлбарласан билээ.

Эцэст нь хэлэхэд тува хэлэн дэх монгол хэлний “хэлний контакт”-ын талаар зөвхөн зээлдсэн үг, дүрслэх үг төдийгүй, цаашдаа хэлний тал бүрийн судалгааг улам гүнзгийрүүлэн хийвэл зохистой гэж үзэж байна.

АШИГЛАСАН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Дорлиг, Ц., Дадар-оол, Б., 1994, *Тыва-Моол словарь*, Өлгий.

Krueger, J.R., 1977, *Tuvan Manual*, Indiana University, Bloomington.

Муниев, Б.Д., 1977, *Калмыцко-Русский словарь*, Москва.

中嶋善輝, 2008, 『トゥヴァ語・日本語小辞典』, 東京外国語大学アジア・アフリカ言語文化研究所.

内蒙古大学蒙古学研究院, 蒙古語文研究所編, 1999, 『蒙漢辞典』, 内蒙古大学出版社, 呼和浩特.

Пальмбаха, А.А., 1955, *Тувинско-Русский словарь*, Москва.

Ramstedt, G.J., 1935, *Kalmückisches Wörterbuch*, Helsinki.

Рассадин, В.И., 1980, *Монголо-Бурятские заимствования в Сибирских Тюркских языках*, Москва.

Тенишев, Э.Р., 1968, *Тувинско-Русский словарь*, Москва.

Цинциус, В.И., 1975, *Сравнительный словарь Тунгусо-Маньчжурских языков* Том I, Ленинград.

Цэдэндамба, Ц., 1997, *Монгол-Орос толь*, Улаанбаатар.

Цэндээ, Ю., 2001, *Дөрвөд аялгууны язгуурлаг үгс*, Улаанбаатар.

Черемисов, К.М., 1973, *Бурятско-Русский словарь*, Москва.

确精扎布, 納·格日勒圖編, 1998, 『衛拉特方言詞彙』, 内蒙古大学出版社, 呼和浩特.

Шинжлэх Ухааны Академи Хэл Зохиолын Хүрээлэн, 2008, *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь I-V*, Улаанбаатар.

ヤマーフー バダムハンド, 2008, 「モンゴル語の形状語の言語学的特徴について——一部日本語のオノマトペと比較して——」, 『日本モンゴル学会紀要』第38号, pp.3-17.

ヤマーフー バダムハンド, 2010, 『モンゴル語の形状語に関する研究』, 大阪大学言語社会学会博士論文シリーズ Vol.52.

Ямаахүүгийн Бадамханд, 2010, Монгол хэлний дүрслэх үгийн бүтцийн онцлог, *ОЮУНЫ ХЭЛХЭЭ* No. I (06), Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, Улаанбаатар, х.205-213.

(2011. 01. 07 受理)